71

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 14 өдөр    Дугаар А/42    Шивээговь сум

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээнүүдийн 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 08 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар "Сумын 2024 оны төсөв батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээнийнүүдийг 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу ажлын удирдамж төсвийг батлуулан хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж, ажлын удирдамжийн дагуу гүйлгээг хийж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргалд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА    Н.СУГАРМАА

D:\My Documents\zaxiramj.doc

42124 178

Сумын Засаг даргын 2024 оны 03-р сарын 14-ны өдрийн А/42 дугаар захирамжийн хавсралт

ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Хүүхэд гэр бүл, нийгмийн орчинд эрүүл амьдрах, сурч боловсрох, хамгаалуулах эрхийг хангах хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, залуучууд орон нутгийнхаа хөгжил, нийгэм эдийн засаг соёлын амьдралд идэвхитэй оролцох, гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, замаар хүүхэд залуучуудад ээлтэй орчин бүрдүүлэх, ёс суртахуунтай, бүтээлч иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

| № | Хөтөлбөрийн зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Санхүүгийн эх үүсвэр | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***1. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, АХМАД НАСТАН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД*** | | | | | | | |
| 1.1 | Хүүхэд бүрийн сурч хөгжих боломжийг дэмжих, хүүхдийг дэмжсэн зэрэг гэр бүлийг төлөвшүүлэх | Хүүхэд залуучуудын сурч хөгжих боломжоор хангаж, сургалтууд зохион байгуулсан байна. | -сургалтанд хамрагдсан иргэдийн тоо<br>-Арга хэмжээ | - 100 хувь<br>4 | - | 2024 | ЗДТГ-ын дарга, НБМ |
| 1.2 | Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настанд эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настанд эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан тоо | 100 | - | 2024 | ЭМТ, НБМ |
| 1.3 | Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулах | Хүүхдийн эрхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх | Арга хэмжээ | 100 | 2,000,0 | 2024 06.01 | ЗДТГ |
| 1.4 | Төрийн албан хаагчдын зөвөлгөөн зохион байгуулах | Төрийн албан хаагчдын туламдаж буй асуудлыг шийдвэрлэж арга зүйн зөвөлгөө өгнө. | Хамрагдсан албан хаагчдын тоо | 100 | 2,000,0 | 2024 5 сард | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Ахмадын баяр зохион байгуулах | Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх | - | 100 | 2,000,0 | 2024 | ЗДТГ |
| 1.6 | Цагаан сарын хүндэтгэлийн арга хэмжээ | Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх | - | 100 | 1,000,0 | 2024 | ЗДТГ |
| **2. “Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **1.5** Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ. | Улс, аймаг болон олон улсын чанартай тэмцээнд оролцсон хүүхэд, иргэдийг дэмжих | Хүүхэд залуучууд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | | | 5,000,0 | 2024 | ЗДТГ |
| | Говьсүмбэр аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бага наадам зохион байгуулах | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш оролцоог хангаж ажиллана. | Урлаг, спортын арга хэмжээ | 100 | 4,000,0 | 2024 4 сард | ЗДТГ |
| | Сумын иргэдийн дунд спортын арга хэмжээ зохион байгуулж иргэдийн бие бялдар төлөвшүүлэх | Залуучуудын спортын арга хэмжээ зохион байгуулах | -Арга хэмжээ -Хамрагдсан залуучуудын хамрагдалтын хувь | 2 | 5,000,0 | 2024 9 сард | ЗДТГ |
| | Малчин залууст чиглэсэн соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах | Малчин залуусын идэвхи оролцоог нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ Хамрагдсан залуучуудын хамрагдалт-ын хувь | Малчин залуусын 30-аас доошгүй хувийг хамруулсан байна. | | 2024 9 сард | ЗДТГ |
| **1.5.4** Аймгийн Засаг даргын 2019 оны 08 | Төрийн албан хаагчдыг 7 хоногт 1 удаа идэвхтэй | албан хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, чийрэгжүүлнэ. | Зохион байгуулсан арга | Хамрагдалтын хувь. | | 2024 | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| дугаар сарын 08-ны өдрийн А/184 дугаар захирамжийн дагуу байгууллага бүр албан хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах “Спортын хамтлаг”-ийг байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, нийтийн цэнгээнт бүжгийн уралдаан тэмцээнд албан хаагчдыг хамруулах | хөдөлгөөн, дасгал хийлгэн | | хэмжээний тоо | | | | |
| | Албан байгууллага, ААН, Иргэдийн дунд чөлөөт бүжгийн challeng зохион байгуулна. | Иргэдийн эрүүл идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Албан байгууллага, ААН, Иргэдийн 1 удаа зохион байгуулна. | | 2024 | ЗДТГ |
| **1.5.3** “Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажлыг эрчимжүүлэх | Төрийн албан байгууллагын эцэг эхийн зөвлөлийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулна. | Эцэг эхчүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ Хамрагдсан хувь | Эцэг эхийн зөвлөлийг 100 хувь хамруулсан байна. | 1,000,0 | 2024 | ЗДТГ |
| | Хүүхдийн барыг тохиолдуулан гар зургийн уралдаан зохион байгуулна. | Эцэг эх хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1-удаа | | 2024 | ЗДТГ |
| | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд хөгжөөнт тэмцээн зохион байгуулна. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1-удаа | | 2024 | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.7.3** Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон төрийн байгууллагуудын албан хаагчдын уламжлалт монгол бичгийн чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон төрийн байгууллагуудын албан хаагч, иргэдийн дунд монгол бичгийн олимпиод зохион байгуулна. | Уламжлалт монгол бичгийн чадварыг дээшлүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1-удаа | 1.000.000 | 2024 | ЗДТГ |
| | Төрийн байгууллагуудын монгол бичгийн түвшин тогтоох сорилтод хамруулна. | Уламжлалт монгол бичгийн чадварыг дээшлүүлнэ | Монгол бичгийн түвшин тогтоох сорилтод хамруулна. | Төрийн албан хаагчдыг 100 хувь хамруулсан байна. | | 2024 | ЗДТГ |
| ***3.*** Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээний хүрээнд | | | | | | | |
| **1.7.1** Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 108 дугаарт ирсэн дуудлага мэдээллийн дагуу нөхцөл байдлын судалгаа хийж, кэйс менежментийг оновчтой тодорхойлох | Ирсэн дуудлага бүрт нөхцөл байдлын судалгаа хийсэн тоо, кэйс хаасан тоо | Нөхцөл байдлын судалгаа хийсэн тоогоор Кэйс хаасан тоогоор | 2024 | Сумын хамтарсан баг | 1,2-р багийн засаг дарга | |
| | Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа гэр бүл, хүүхдүүдийн судалгаа нэгдсэн маягт асуулгыг боловсруулж, мэдээллийн сантай болно. | Эрсдэлт нөхцөлд амьдарч буй гэр бүл хүүхдийн судалгааг гаргах | Эрсдэлт нөхцөлд амьдарч буй гэр бүл хүүхдийн судалгааг гаргасан байна. | 2024 | Сумын нийгмийн бодлогын мэргэжил-тэн | 1,2-р багийн засаг дарга | |
| | Мансуурүулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, электрон | Гарын авлага тараасан тоо Сургалт зохион байгуулсан | Гарын авлага тараасан тоо - 100-с дээш Сургалт | 2024 | 200.0 | 1,2-р багийн засаг дарга | Сумын нийгмийн бодлогын мэргэжил- |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тамхины хор уршиг, үр дагаврын талаар дунд ахлах ангийн сурагчдад сургалт зохион байгуулах | тоо | зохион байгуулсан тоо-1 | | | Цагдаа ЕБС | тэн |
| | Эцэг эхийн хараа хяналт муу, аав ээж нь архины хамааралтай амьдардаг хүүхдийн судалгааг гарган, учирч болох эрсдэлээс сэргийлэх | Судалгаа үнэн зөв дэлгэрэнгүй байх, Хүүхдийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны тоо | Гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй хүүхдийн судалгаа үнэн зөв байх, Хүүхдийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны тоо-2, | 2024 | Сумын нийгмийн бодлогын мэргэжил-тэн | 1,2-р багийн засаг дарга Цагдаа ЕБС | |
| | ЕБС-ийн сурагч нарын дунд “штрок”-ын уралдаан зарлах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Зохион байгуулсан арга хэмжээний тоо-1 | 2024 | 300.0 | 1,2-р багийн засаг дарга ЕБС | Сумын нийгмийн бодлогын мэргэжил-тэн |
| | Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх /Хүчирхийлэлгүй гэр бүл аяныг зохион байгуулах/ | Зохион байгуулах арга хэмжээний тоо Хамруулах өрхийн тоо | 100 хувь зохион байгуулсан байна. | 2024 | 500.0 | 1,2-р багийн засаг дарга ЕБС | Сумын хамтарсан баг |
| | Архидалтгүй Шивээговь өдөрлөг зохион байгуулах | Архины эмчилгээнд хамруулах | Архины хамааралтай иргэдийн тоо эмчилгээнд | 2024 | 1.000.0 | 1,2-р багийн засаг дарга | Сумын хамтарсан баг |

76

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамрагдсан тоо-1 | | | | |
| | Шаардлагатай туслалцаа хэрэгтэй өрхөд бараа материалаар туслах | Тусламж үзүүлсэн өрхийн тоо | Тусламж үзүүлсэн өрхийн тоо | 2024 | 500.0 | | Сумын хамтарсан баг |
| | Дуудлаг мэдээллийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийх, тусламж үзүүлэх, сургалтад хамрагдахад шаардагдах шатхууны зардал | Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн өрхийн тоо Хамрагдсан сургалтын тоо | | 2024 | 500,0 | | Сумын хамтарсан баг |
| | Итгэлт утас | Сургуулийн орчин бий болж буй хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авч хариу үйлчилгээ үзүүлэх | хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авч хариу үйлчилгээ үзүүлсэн тоо | 2024 | Сумын хамтарсан баг | Сургуу-лийн нийгмийн ажилтан цагдаа | Сумын хамтарсан баг |
| **Арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай төсвийн задаргаа** | | | | | | | |
| Нийт дүн | | | 30,000,000 | | | | |

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН Б.АЛТАНСҮХ

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

УСА0004 9018441